

МОНГОЛ-ВЬЕТНАМЫН ХАРИЛЦААНЫ ҮЕЧЛЭЛ

Б.Цэнгэлхам*

Монгол, Вьетнамын харилцаа дундад эртний үеэс эхлэлтэй бөгөөд энэ харилцаа хоёр орны ард түмний хоорондын чин сэтгэлийн найрсаг харилцаа болж чадсанаараа онцлогтой юм. Энэхүү түүхэн уламжлалт, найрсаг харилцааг хөгжлийн хувьд нь дараахь байдлаар 4 үед ангилж болно.

1. Вьетнамын дайнаас өмнөх үеийн харилцаа

Монгол, Вьетнамын харилцаа их эртний уламжлалтай², бүр XIII зууны үеэс эхлэлтэй гэж үзэж болно. Монголын Эзэнт гүрэн Зүүн Өмнөд Азийн орнуудаас хамгийн түрүүнд Аннамтай цэрэг, улс төрийн талаар харилцаж эхэлжээ.³ 1251-1259 онд Монголын Эзэнт гүрний хаан ширээнд суусан Мөнх хаан өмнөх хаадын баримталж байсан гадаад бодлогыг үргэлжлүүлэн Эзэнт гүрний эргэн тойронд байсан улс гүрнүүдийг эрхшээн нэгтгэх аян дайныг үргэлжлүүлжээ. Энэ дагуу Мөнх хааны Зарлиг болгосноор Сүн улсыг буулган авахаар 4 замаар довтолгооноо эхлүүлсэн ба өмнө зүгээс нь эзлэн довтолхын тулд тэр үеийн Их Вьет улсын нутаг дэвсгэрийг ашиглах буюу дайрч өнгөрөх шаардлагатай байв. Иймд Мөнх хаан 3 удаа элч илгээсэн боловч Их Вьет улс будааж явуулаагүй учир 1258 оны эхээр Монголын Эзэнт гүрний болон Хойд, Өмнөд Хятад, Хайнаны нийт 3 түмэн цэрэг анх удаа довтолжээ. Энэ удаагийн довтолгооноор Монголын Эзэнт гүрний цэрэг Их Вьет улсыг эзэлж авч чадалгүй буцсан байна. Харин Их Вьет улсын хаан элч илгээж Монголын Эзэнт гүрэнд 3 жилд 1 удаа алба, өргөл барьц барьж байхаар тохиролцов. Их Вьет улс Мөнх хааны дараа төр барьсан Хубилай хааны хаанчлалын жилүүдэд Их Монгол Улсад өргөл барьцаа үргэлжлүүлэн барьсаар байсан хэдий ч далдуур өөрийн улсын цэргийн хүчээ зузаатгахад ихээхэн анхаарал хандуулж байжээ. Өөрийн орны дотоод дахь асуудлыг хэвийн болгож чадсан Хубилай хаан өмнөх хаадын нэгэн адилаар Сүн улс руу довтолхоор бэлтгэж эхэлсэн ба ингэхийн тулд Их Вьет улсын талаар хатуу бодлого явуулах, өөрийн гүрэнд сайн дураар нэгдэн орохыг шаардаж эхэлсэн байна. Үүнийг Их Вьет улсын хаан хүлээж авалгүй, харилцан мэтгэлцэх байдлаар 10 гаруй жил болсон ба 1279 онд Хубилай хаан Сүн улсыг буулган авснаар Монголын Эзэнт гүрэн Их Вьет улстай шууд хил залгах болж, энэ нь Зүүн Өмнөд Азийг өөрийн эрхэнд оруулахад чухал байршил болов.

Юань улсын бодлого, үйл ажиллагааг Зүүн Өмнөд Азийн орнууд янз янзаар хүлээн авч байв. Мэдээж Их гүрний сүр хүчээр далайлгасан, тэгш биш тэрхүү бодлогод ихэнх улс орнууд дургүйцэн эсэргүүцэж байв.

* Б.Цэнгэлхам - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Гэвч улс орон бүрийн дотоод, гадаад нөхцөл байдал өөр өөр байснаас зарим нь хүчтэй эсэргүүцэж, зарим нь төдийлөн их тэмцэхгүй Юань улсын эзэн эрхийг хүлээн зөвшөөрч байв.⁴ Үүний дараа 1285 онд Хубилай хааны Зарлигаар Монголын Эзэнт гүрний цэрэг 2 дахь удаагаа Их Вьет улс руу довтолжээ. Энэ удаагийн довтолгоон амжилттай болж нийслэл хотыг нь эзлэн авсан боловч Их Вьет улсын хаан урагшаа зугтаасан учир буулган авч чадалгүй нутаг буцсан байна. 1288 онд хоёр талын цэрэг нүсэр тулаан хийсэн боловч хэн нь ч ялсангүй. Аннамын усан цэрэг Монголын усан цэргийг ялж Омарыг олзлон авч цэргийг нь үлдэн хөөсөн боловч хуурай газрын тулалдаанд цохигджээ. Тиймээс тамирдаж сульдсан хоёр талын цэрэг тулалдааны талбарыг орхин хоёр тийш ухарчээ. Үүний дараа монгол цэрэг Аннамыг орхиж гарсан боловч дайн хэзээ хэзээгүй дахин эхэлж болохоор байв. Гэтэл Аннамын цэрэг эдийн засгийн чадавхи шавхагдаж дахин том дайны хөлийг давахааргүй доройтож өлсгөлөн эхэлсэн явдал Аннамын эрх баригчдыг сүрхий зовоох болсонд 1288 оны сүүлээр Ханбалиг өөд элч томилон найрамдал гуйжээ. Ханбалигт болсон хэлэлцээний явцад Аннам улс Монголын түшмэг болсоноо хүлээн зөвшөөрч жил бүр Юань гүрэнд алба хүргүүлж байх болов. Ийнхүү цэрэг зэвсгийн шахалтыг дипломат аргатай хослуулан санасандаа хүрэх гэсэн Хубилай хааны бодлого хэрэгжиж чаджээ.⁵

Энэ үеийн дайн байлдааны талаар Вьетнамын болон Юань гүрний түүхэн сурвалж бичгүүдэд тодорхой тэмдэглэгдэн үлдсэн байдаг гэх бөгөөд бараг бүгдэд нь Монголын Эзэнт гүрний цэрэг Их Вьет улсын цэрэгт ялагдсан хэмээн бичсэн байдаг ажээ. 1257-1288 онд Монголын Эзэнт гүрний цэрэг Их Вьет улс руу 3 удаа довтолж ялагдав.⁶ Гэхдээ манай судлаачдын үзэж байгаагаар Монголын Эзэнт гүрний цэрэг ялагдаагүй, нутаг буцахад цаг агаарын ондоо байдал, чийг, намаг, хоол хүнсний хомсдол болон халуун орны өвчин гэх мэт шалтгаанууд нөлөөлсөн.

Дурьдан буй үеийн Монголын Эзэнт гүрэн, Их Вьет улсын хоорондох харилцааны агуулгыг зөвхөн дайн байлдаан, улс төрийн харилцаагаар хязгаарлаж болохгүй бөгөөд хоёр талаас харилцан солилцож байсан элч төлөөлөгчид нь бие биенийхээ түүх, соёл, ёс заншил, хүчээ аван хөгжиж байсан бурханы шашныг судалж, тэр тухайгаа тэмдэглэн үлдээсэн байдаг аж. Энэ үеийн харилцаанд хүчтэй нь хүчгүйгээ эрхшээлдээ цэрэг зэвсгийн хүчээр оруулдаг байсан дундад эртний үеийн хэв маяг давамгайлж байсан байна.

2. Вьетнамын дайны үеийн харилцаа

Монгол, Вьетнамын ард түмний түүхэн, уламжлалт, найрсаг харилцаа улам дотно болж байлаа. 1960-аад оноос Энэтхэг-Хятадын хойгт өрнөсөн дайн нь нэг талаас АНУ тэргүүтэй улс орнууд нөгөө талаас ЗСБНХУ тэргүүтэй коммунистуудын ашиг сонирхлын

мөргөлдөөний талбар болж хувирчээ. Энэ үед социалист нөхөрлөлийн орнууд дуу нэгтэйгээр Вьетнамыг дэмжсэн үйл ажиллагаа, бодлого явуулж байв. БНМАУ мөн адил, социалист нөхөрлөлийн гишүүн орнуудын нэгний хувьд Вьетнамын талд байж, БНСВУ-тай улс төр, соёл, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхийн зэрэгцээ эх орныхоо төлөө тэмцэж байгаа вьетнам анд нөхөлдөө туслах хөдөлгөөнийг өөрийн орны өнцөг булан бүрт өрнүүлж байжээ. Тухайн үед нэн ялангуяа улс төрийн харилцаа сайн хөгжиж байв. Дайны эхний жилүүдэд ч харилцан айлчлал хийгдэж байжээ. Тухайлбал, 1966, 1967 онд манай хоёр орны нам засгийн олон зочид төлөөлөгчид албан ёсны айлчлал хийсэн байна. Энэ үед манай төр засаг Вьетнамын ард түмэн Женевийн хэлэлцээрийн дагуу асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрхтэй гэсэн хатуу байр суурийг баримталж, түүнийгээ удаа дараа мэдэгдэж байжээ.

Монголын ард түмэн, төр засаг Францын колоничлолыг эсэргүүцсэн Вьетнамын ард түмний шударга тэмцлийн талд бат зогсч, сэтгэл санааны асар их дэмжлэг үзүүлж байжээ. 1946 онд Франц Улс Вьетнам руу дахин довтолсон явдлыг бас эрс эсэргүүцэж байв. Вьетнам-Америкийн дайны үед Монголын ард түмэн эртний түүхэн уламжлалт найрсаг харилцаатай Вьетнамын ард түмэнд сэтгэл санаа, эд материалын тусламж дэмжлэгийг харамгүй үзүүлсэн билээ. Үүнийг Вьетнамын төр засаг, ард түмэн одоо ч үргэлж санаж дурсан, “Вьетнамын ард түмэн биднийг зовлон зүдгүүр үзэж, дайны хөлд нэрвэгдэж байхад Монголын төр засаг, ард түмний чин сэтгэлийн үнэлж баршгүй их тусламж дэмжлэгийг бид мартаагүй, мартахагүй, үр хойчдоо таниулан мэдүүлж, үргэлж бахархаж явах болно” гэдгээ байнга илэрхийлж байдаг билээ.

Вьетнамын дайны үед харийн түрэмгийлэгчдийн өдөөж байгаа дайныг эсэргүүцсэн мэдэгдлүүд БНМАУ-ын сонин хэвлэлүүдэд удаа дараалан гарч байжээ.⁷ Вьетнам-Америкийн дайны үед улс орнуудын үзүүлсэн тусламж дэмжлэгийг тухайн улсын хүн амд харьцуулсан байдлаар манай улс нэгдүгээрт ордог гэсэн тоон үзүүлэлт байдаг. Гэхдээ энэ нь зөвхөн материаллаг тусламжийг тооцсон үзүүлэлт. Үүнээс гадна дайны хөлд нэрвэгдэн зовж зүдэрч байсан Вьетнам анд нөхөлдөө үзүүлсэн манай ард түмний сэтгэл санааны тусламж дэмжлэгийг үнэлж баршгүй. Жишээлбэл, Вьетнам анд нөхөлдөө зориулж зохиосон дуу шүлэг, Вьетнамын дайныг эсэргүүцэн Монголд олноор зохион байгуулагдаж байсан олон нийтийг хамарсан арга хэмжээнүүд олон байв.

1950 онд Вьетнамын Засгийн газар санаачлан социалист орнуудын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд дипломат харилцаа тогтоох саналыг тавьж байжээ. 1954 онд Монголын тал санаачлан дипломат харилцаа тогтоох саналыг Хятадад суугаа ЭСЯ-аараа дамжуулан тавьсан бөгөөд хоёр талд зэрэг нэг өдөр буюу 11-р сарын

17-нд зарласан байна. 1956 оны 8-р сарын 26-нд Монгол, Вьетнамын тал Элчин яамдыг Элчин сайдын яам болгон өөрчилжээ. БНМАУ-аас БНАВУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт анхны Элчин сайд Б.Очирбат⁸ 1956 оны 8-р сарын 30-нд тус улсын Ерөнхийлөгч Хо Ши Минд Итгэмжлэх Жуух Бичгээ барьжээ.

1954 онд дипломат харилцаа тогтоосны дараа 1955 оны 7-р сард БНАВУ-ын Ерөнхийлөгч Хо Ши Мин БНМАУ-д, 1959 оны 12-р сард МАХН-ын Намын Төв Хорооны Нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал БНАВУ-д албан ёсны айлчлал хийж, хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны эх суурийг тавьсан байна.

Хоёр орны харилцаа хөгжиж, 1957 онд худалдааны анхны хэлэлцээр, 1958 онд соёлын хамтын ажиллагааны анхны хэлэлцээрийг Ханой хотноо тус тус байгуулсан байна. Вьетнамын Засгийн газрын төлөөлөгчид 1955, 1959, 1961, 1973 онд, Үндэсний Ассамблейн төлөөлөгчид 1958, 1973 онд манай улсад, манай Засгийн газрын төлөөлөгчид 1959, 1967 онд тус тус Вьетнамд айлчилсан байна.

3. Вьетнамын дайны дараах үеийн харилцаа

Вьетнамын дайны дараа ч манай хоёр орны харилцаа сайн хэвээр байсан. 1975 онд Вьетнамын ард түмэн Америкийн цэргийн түрэмгийллээс бүрэн ангижирч, хоёр хуваагдаад байсан улс үндэстнээ нэгтгэж, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс бий болсон. Энэ нөхцөл байдалд манай хоёр орон аль аль нь улс төр, эдийн засгийн харилцааг цаашид хөгжүүлэх хүсэл эрмэлзлэл нэгтэй байжээ. Гэхдээ үүгээр Вьетнамын дайн хараахан дуусаагүй юм. Учир нь 1975 онд Өмнөд Вьетнам чөлөөлөгдөж, нэгдсэн Вьетнам улс бий болсон нь Америкийн империализмтай хуйвалдаж байсан Хятадын эрх баригчдын хүсэл зорилгод нийцсэнгүй. Иймд Вьетнамыг эсэргүүцэхийн тулд нэг талаас Пол Потын харгис бүлгийг ашиглан⁹ Вьетнамын эсрэг хилийн дайн дэгдээсэн байна.

1979 оны 2-р сарын 17-нд Бээжингийн эрх баригчид олон улсын харилцааны үндсэн зарчим, НҮБ-ын дүрмийн заалтыг бүдүүлгээр зөрчин БНСВУ-ын эсрэг зөвсөгт түрэмгийлэл үйлдсэн¹⁰ билээ. Энэ дайн Хятадын хувьд Бээжингээс Вьетнамыг жанжлах бодлогоо хэрэгжүүлэхэд шинэ нөхцөл байдлыг бий болгохоос гадна АНУ-тай ойртон түншлэхэд улс төрийн хөшүүрэг болох ёстой байв.¹¹ Тэр бүрт манай улс буруушаан, сонин хэвлэлээр улс орон даяар мэдэгдэл гарган эсэргүүцэж байв. Тухайн үеийн хоёр орны харилцааг дараах байдлаар авч үзэж болно.

Улс төрийн харилцаа: Монголын ард түмэн, төр засаг Вьетнамын ард түмэн, төр засагтай найрсаг харилцааг хэвээр хадгалж, тэдний явуулж буй бодлого, үйл ажиллагааг дэмжиж байв. Вьетнамыг НҮБ-д

гишүүнээр элсүүлэх, энэ асуудлыг шударга зөвөөр шийдвэрлүүлэхийг хүссэн тогтоолын төслийг Аюулгүйн Зөвлөлд оруулсан санаачлагчдын нэг нь БНМАУ байсан юм. БНСВУ НҮБ-д гишүүнээр элссэн явдал олон улсын байгууллагын гишүүн улсуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх таатай боломж болжээ. Бүс нутгийн болон олон улсын байдалд гарч буй зарим өөрчлөлтүүд, мөн 1961 онд батлагдаж, 1979 онд дахин шинэчлэгдсэн хоёр улсын Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд тулгуурлан хоёр орны харилцаа хөгжиж ирлээ.

Вьетнамын Засгийн газрын төлөөлөгчид 1984, 1995, 1999 онд, Үндэсний Ассамблейн төлөөлөгчид 1973, 1987 онд, Гадаад явдлын яамны сайд 1982 онд айлчилсан, манай Засгийн газрын төлөөлөгчид 1967, 1979 онд, Их Хурлын төлөөлөгчид 1983 онд, Гадаад харилцааны сайд 1985 онд тус тус Вьетнамд айлчилжээ.

Эдийн засгийн харилцаа: “Хүйтэн дайн”-ы үед буюу 1956-1990 онд манай улсын Засгийн газраас Вьетнамын Засгийн газарт хуучин ханшаар 200 сая гаруй төгрөгийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгожээ. Тэр үеийн манай хоёр орны харилцааг “Хүйтэн дайн”-ы улбаагаар социалист эвслийн хүрээнд тодорхойлон авч үздэг. Хэдийгээр ихэнх судлаачид манай хоёр оны харилцааг 1990-ээд оны үед улс төрөөс бусад салбарт зогсонги байдалд ороод байсан гэж дүгнэдэг ч түүхэн баримтыг эргэн харахад хараахан ийм дүгнэлт хийж боломгүй юм. Тухайн үед хоёр улсын хоорондын барааны эргэлт бууралтад ороод байсан боловч нэг нь нөгөөгөө дэмжиж ирсэн уламжлалт найрсаг харилцаа байсаар байсныг зарим нэг баримтаар нотолж болно. Тухайлбал, 1993 онд манай улс картын системд шилжээд байхад Вьетнамын талаас шилжилтийн хүнд бэрх үед хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд зориулж 200 мянган ам.долларын буцалтгүй тусламж үзүүлжээ.¹²

Бусад салбарын харилцаа: 1958 оны 2-р сард батлагдсан хоёр орны Засгийн газрын хооронд соёлын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн дагуу Монгол, Вьетнам жүжигчид, уран бүтээлчид харилцан айлчилж, тоглолт хийж байжээ. Монголын уран бүтээлчид хамгийн анх 1958 онд Вьетнамд, харин Вьетнамын уран бүтээлчид 1962 онд Монголд тоглосон.

1977 оны 6-р сарын 3-ны өдөр БНМАУ, БНСВУ-ын Засгийн газрын хооронд соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг дахин шинэчлэн баталжээ.¹³ Түүнээс хойш Вьетнамаас Монголд ирж суралцаж төгссөн оюутнуудын тоо Монголоос Вьетнамд очиж суралцсан оюутнуудын тооноос хэд дахин их байгаа нь дайны хор уршиг бүрэн гүйцэд арилаагүй, амьдрах нөхцөл байдал тааруу зэрэг шалтгаануудтай холбоотой гэж би үзэж байна.

Соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн хүрээнд 1985 онд Монголд Вьетнамын соёлын өдрүүд, харин 1987 онд Вьетнамд Монголын соёлын өдрүүд амжилттай зохион байгуулагдсан байна.

БНМАУ-ын Засгийн газар Вьетнамд 1956–1990 онд нийтдээ 200 сая гаруй төгрөгийн (хуучин ханшаар) буцалтгүй тусламж үзүүлжээ. Үүний зэрэгцээ манай олон нийтийн байгууллагуудын шугамаар 904.8 мянган төгрөгийн тусламж үзүүлсэн байна. Мөн 1959 онд бэлэг болгон өгсөн 100 мянган толгой малаас үлдсэн 85 мянган толгой малын оронд гуравдагч орноос үржлийн үхэр худалдан авахад нь зориулж 1,5 сая ам.доллар өгчээ.

Дайны дараах хүнд нөхцөлд байсан Вьетнамын ард түмний амьдрал, төр засгийн үйл ажиллагаанд манай ард түмэн, төр засаг тусламж дэмжлэг үзүүлж, оюутан сурагчдыг нь өөрийн оронд сургаж, дээд боловсрол олгоход ихээхэн анхаарч ажилласан бол Вьетнамын ард түмэн, төр засаг Монголын шилжилтийн хүнд бэрх жилүүдэд манай орны оюутан залуусыг өөрийн оронд боловсрол эзэмшүүлэхэд идэвх зүтгэл гарган ажиллаж байжээ. Энэ нь хүнд бэрх үед бие биесээ дэмжин, түүхэн уламжлалт, найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам хөгжүүлсэн чухал ажлууд болжээ гэж дүгнэж болохоор байна.

4. Өнөөгийн харилцаа

1990-ээд оны үед зогсонги байдалд ороод байсан манай хоёр орны харилцаа сүүлийн үед бүх салбарт маш эрчимтэй өрнөж байна. БНМАУ 1954 оны 11-р сарын 17-нд БНАВУ-тай дипломат харилцаа албан ёсоор тогтоосон хэдий ч мөн чанартаа манай хоёр орны харилцаа уламжлалт, түүхэн, найрсаг харилцаа юм. 1991 оныг хүртэл хоёр орны харилцаа социалист хамтын нөхөрлөлийн хүрээнд явагдаж, хоёр талаас өндөр, дээд хэмжээний айлчлалууд харилцан хэрэгжиж хэвшсэн байв. 1961 онд байгуулж, 1979 онд шинэчлэн баталсан Найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээг 2000 онд дахин шинэчилжээ.

Улс төрийн харилцаа: Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат 1994 оны 3-р сард БНСВУ-д албан ёсны айлчлал хийж, энэ үеэр Монгол-Вьетнамын хамтарсан тунхаглал байгуулав.

БНВСУ-ын Гадаад хэргийн сайд Нгуен Мань Кам 1995 оны 5-р сард манай улсад айлчлах үеэр “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”-ний шинэчилсэн төслийг үзэглэж, ГХЯ-дын хамтын ажиллагааны тохиролцоог байгуулжээ. Мөн хоёр тал Давхар татварын тухай Хэлэлцээрт гарын үсэг зуржээ.

УИХ-ын дарга Р.Гончигдорж тэргүүтэй төлөөлөгчид 1998 оны 11-р сард Вьетнамд албан ёсны айлчлал хийж, тэр үеэр УИХ, Вьетнамын Үндэсний Ассамблейн хооронд хамтран ажиллах Протокол, мөн дээрх байгууллагуудын Тамгын газруудын хооронд

хамтран ажиллах Протоколд тус тус гарын үсэг зурсан юм. Энэ үеэр Вьетнамын Үндэсний Ассамблейн дарга Нонг Дык Манийг Монгол Улсад айлчлахыг урьсан байна.

Хоёр орон олон улс, бүс нутаг, НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын хүрээнд хамтран ажиллаж ирэв. Вьетнамыг НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн зөвлөлд болон ДХБ-д гишүүнээр элсэхэд болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүнээр сонгогдоход Монгол Улс, манай улсыг АСЕМ болон АСЕАН-ны бүсийн чуулганд элсэхэд Вьетнам улс дэмжсэн.

БНСВУ-ын Ерөнхий сайд Фан Ван Кхай 1999 оны 10-р сарын 2-нд Монгол Улсад ажлын айлчлал хийсэн. Айлчлалын үеэр хоёр орон, ард түмэн найрсаг харилцаатай явж ирсэн уламжлалдаа түшиглэн XXI зуунд хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэх чиг шугам баримталж байгаагаа талууд харилцан нотлов.

Сүүлийн жилүүдэд сэргэн өргөжих хандлагатай байгаа хоёр талын хамтын ажиллагааг улам бататгах үүднээс өндөр, дээд болон янз бүрийн түвшинд төлөөлөгчид харилцан айлчлуулах зэргээр солилцоог идэвхжүүлэх нь зүйтэй гэж үзээд Монгол, Вьетнамын хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа хөгжүүлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглахад хоёр орны бизнесийн хүрээнийхний харилцааг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг талууд тэмдэглэсэн байна. Монгол Улс Ази, Номхон далайн улс төр, эдийн засгийн интеграцид нэгдэн нийлж, цаашид идэвхтэй оролцохдоо Вьетнамтай ойр дотно хамтран ажиллахад ач холбогдол өгдөг. Вьетнам улс тус бүс нутгийн орнууд, түүний дотор Монгол Улстай олон улс, бүс нутгийн хэмжээнд идэвхтэй хамтран ажиллах бодлого барьж байгаагаа мэдэгдсэн.

Иргэд харилцан зорчих нөхцлийн тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг 1999 оны 12-р сард байгуулав.

БНСВУ-ын Ерөнхийлөгч Чан Дык Лыонг тэргүүтэй төлөөлөгчид 2000 оны 4-р сарын 15-17-нд Монгол Улсад төрийн ёсны айлчлал хийж, хоёр орны хооронд зарим салбарт хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.

Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун 2001 оны 7-р сард БНСВУ-ын Гадаад хэргийн сайд Нгуен Зы Ниены урилгаар БНСВУ-д айлчилж хэлэлцээ хийж, өөрийн орны нийгэм, эдийн засгийн байдал, гадаад бодлогын талаар харилцан мэдээлж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа болон олон улсын сонирхсон асуудлаар санал солилцов. Айлчлалын үеэр “Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурав. Мөн Гадаад хэргийн яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг тогтмолжуулах чиглэлээр ажиллахыг тохиролцсон байна.

2002 оны 10-р сарын 2-6-нд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр гэргийн хамт БНСВУ-ын Ерөнхий сайд Фан Ван Кхай-ын урилгаар Вьетнамд албан ёсны айлчлал хийв. Тус айлчлал нь Монгол, Вьетнамын уламжлалт найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг хоёр улсын ард түмний эрмэлзлэл, эрх ашигт нийцүүлэн, Ази, Номхон далайн бүс нутаг, дэлхий дахины энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааны тусын тулд цаашид бататган хөгжүүлэх үйлст түлхэц болсон гэж хоёр тал үзсэн ба айлчлалын үеэр зарим салбарт хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Айлчлалын үеэр Монгол, Вьетнамын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хамтарсан хөрөнгө оруулалтай УЦС барьж байгуулсан уламжлалаа сэргээх, хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газруудыг хөдөө аж ахуй, мал аж ахуйн түүхий эд боловсруулах чиглэлээр барьж ажиллуулах, бүтээгдэхүүнийг Орос, Хятадын зах зээлд гаргах, Монголд хөрөнгө оруулалтын хэлбэрээр орон сууц барих боломжийг судлах, арилжааны банк хоорондын хэлэлцээр байгуулж худалдааны төлбөр тооцоонд учруулдаг бэрхшээлийг цэгцлэх, төмөр замын тээвэрт байгаа саадыг зохицуулах үүднээс Хятадтай гурван талын уулзалт хийх талаар хоёр тал тохиролцжээ.

2003 оны 1-р сарын 11-14-нд БНСВУ-ын Үндэсний Их Хурлын дарга Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн ба айлчлалын үеэр Парламент хоорондын хамтын ажиллагааны тухай протокол, Парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны протоколд тус тус гарын үсэг зурав.

2004 оны 1-р сарын 5-аас 11-нд Монгол Улсын Их Хурлын даргын БНСВУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын УИХ-ын дэргэд Судалгааны төвийг байгуулахад Вьетнамын Үндэсний Их Хурлаас тус дэмжлэг үзүүлэх асуудлаар хэлэлцэн шийдвэрлэх, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, мэргэжилтнүүдийг солилцох талаар хэлэлцэн тохиролцов. УИХ-ын даргын улс төрийн зөвлөх, УИХ-ын Бодлогын судалгааны төвийн захирал Г.Чулуунбаатар БНСВУ-д айлчлав. Вьетнамын Үндэсний Их Хурлын Мэдээллийн төвөөс УИХ-ын Бодлогын судалгааны төвд 10 мянган ам.долларыг тусламж болгон өгөв.

БНСВУ-ын Ерөнхий сайд Фан Ван Кхай 2005 оны 5-р сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалаар хамтарсан мэдэгдэл гаргаж Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай болон Шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын Хэлэлцээрт гарын үсэг зурав. Вьетнамын Засгийн газраас манай Засгийн газарт 300 компьютер, техник хэрэгслийг буцалтгүй

тусламж болгон өгч, жил бүр Монголоос 20 оюутныг өөрсдийн зардлаар хүлээн авч сургахаар болсноо мэдэгдэв. Тус айлчлал нь хоёр орны уламжлалт харилцааг хөгжүүлэх, ялангуяа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар ярилцсан нь чухал ач холбогдолтой болсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди гэргийн хамт БНСВУ-ын Ерөнхийлөгч Чан Дык Лыонгийн урилгаар 2005 оны 1-р сарын 19-нөөс 23-нд БНСВУ-д төрийн найрсаг айлчлал хийж, хоёр орны хооронд зарим салбарт хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурав. Айлчлалын үеэр Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, БНСВУ-ын Гадаад хэргийн сайд Нгуен Зы Ниен-тэй уулзаж харилцан сонирхсон асуудлаар санал солилцов. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн БНСВУ-д хийсэн төрийн айлчлал нь хоёр орны ард түмний эрх ашигт нийцсэн, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хөгжилд хувь нэмэр оруулах чухал үйл явдал боллоо гэж хоёр тал үзэв.

БНСВУ-ын ҮИХ-ын Вьетнам, Монголын парламентийн бүлгэмийн урилгаар 2005 оны 11-р сард УИХ-ын Монгол, Вьетнамын парламентын бүлгэмийн дарга Ч.Содномцэрэн тэргүүтэй төлөөлөгчид Вьетнамд айлчилж парламентын бүлгэмийн дарга Лыонг Фан Гытай хэлэлцээ хийв.

2008 оны 10-р сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар БНСВУ-ын Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет гэргийн хамт Монгол Улсад төрийн айлчлал хийв.

Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет, Ерөнхийлөгч Н.Энхбаяр олон улсын болон бүс нутгийн байдал хурдан өөрчлөгдөж, бэрхшээл, сорилт учирч буй өнөө үед хоёр тал НҮБ, олон улсын бусад байгууллагад болон олон талт яриа хэлэлцээний хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь дэлхий дахины болон бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааны төлөө өөрийн улс орноо хөгжүүлэх, олон улсын интеграцид нэгдэх явцыг урагшлуулахад чухал ач холбогдолтой байх болно гэдэгтэй санал нэг байв. Бүс нутгийн олон талт яриа хэлэлцээ, механизмын хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг бэхжүүлж, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад элсэх Монгол улсын хүсэл эрмэлзлийг дэмжиж ажиллахаа Вьетнам улс илэрхийлэв. Монгол Улс 2009 онд болох НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн сонгуульд, Вьетнам улс 2009 онд болох НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын Гүйцэтгэх зөвлөлийн сонгуульд тус тус нэрээ дэвшүүлсэнтэй холбогдуулж, эдгээр сонгуульд харилцан дэмжихээ хоёр тал илэрхийлэв. Дэлхий дахинд болон бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг хангахад Вьетнам Улс НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн байнгын бус гишүүний хувьд бодит хувь нэмрээ оруулж, түүний нэр хүнд олон

улсын тавцанд улам бүр дээшилж байгаад монголын тал баяр хүргэв. Хоёр тал Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн салбарт хамтран ажиллах Вьетнам, Монголын Засгийн газар хоорондын комиссын хүчин чармайлтад баяр хүргэж, энэ оны эцсээр Ханойд хуралдах ЗГХК-ын ээлжит 13 дугаар хурлаар хоёр орны хооронд хамтран ажиллах нөөц боломж бүхий салбаруудад хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар тодорхой шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзэв.

Худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын комисс 1979 онд байгуулагдсан. Засгийн газар хоорондын комиссын хуралдааны хүрээнд яригдсан ажлуудаас хамтын ажиллагааны тодорхой төслүүдэд голлон анхаарч байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Булган суманд Вьетнамын Засгийн газрын дэмжлэгтэйгээр усан цахилгаан станц барих асуудал шийдэгдэх шатандаа явж байна.

Эдийн засгийн харилцаа: Сүүлийн жилүүдэд хоёр орны худалдааны эргэлт жилд дунджаар 1.5 сая ам.доллар байна. 2005 оны эхний хагасын байдлаар худалдаа 1.4 сая ам.долларт хүрсэн нь 2004 оны мөн үетэй харьцуулахад 12.2 %-иар нэмэгдсэн байна. 2006 оны байдлаар Монгол, Вьетнамын худалдаа 2 сая 640 мянган ам.доллар болж өссөн байна. 2006 оны эхний 10 сарын байдлаар хоёр талын худалдааны эргэлт 2 сая 647 мянган ам.доллар буюу өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.5%-иар өссөн дүнтэй, худалдаа урьд жилийн адил Вьетнамын талын урсгалтай байсан бол 2007 онд Вьетнамтай худалдаа 20 гаруй хувиар өсч 4.5 сая ам.доллар болоод байна. Хоёр талын худалдаанд Вьетнамаас хүнсний болон өргөн хэрэглээний бараа голлосон бол Монголоос цахилгаан техникийн эд анги нийлүүлсэн байна. Хоёр орны хоорондох худалдааны эргэлтийг сайжруулах сонирхол хоёр талд адилхан байгаа боловч гагцхүү тээврийн зардал хэт өндөр байгаа ба энэ асуудлаар буюу тээврийн зардлыг багасгах тал дээр Монгол Улс, БНСВУ, БНХАУ-ын хооронд гурван талын хамтарсан уулзалт хийхээр Монгол, Вьетнамын талууд ажиллаж байна.

2005 оны эхний хагасын байдлаар Вьетнамаас Монголд нийт 696 мянган ам.долларын хөрөнгө оруулсан 35 аж ахуйн нэгж бүртгэгдээд байна. Зөвхөн 2005 оны эхний 7 сарын байдлаар 108 мянган ам.долларын хөрөнгө оруулсан 5 аж ахуйн нэгж нэмж бүртгэгдсэн байна.¹⁴ 2006 оны байдлаар Вьетнамаас Монголд 720 мянган ам. долларын хөрөнгө оруулалтай 25 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд авто машины засвар үйлчилгээ, зуучлал, гадаад, дотоод худалдаа, фото зураг, хүнсний ногоо тариалах, хадгалах, тоосгоны үйлдвэрлэл зэрэг чиглэлээр ажиллаж байна. Эдгээр аж ахуй нэгжүүд нь бараг 100% автомашин засвар ажиллуулдаг ба дийлэнх нь

чанарын өндөр түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг ба манай жолооч нарт сэтгэл хангалуун байж чадахуйц үйлчилгээ үзүүлж чаддаг ба гагцхүү үнэ өндөр байна. Мөн зах зээлийн өрсөлдөөний хуулийн дагуу олноор бий болж байгаа вьетнам гэсэн тодотголтой автомашин засварын газруудын цаана үүсч буй сэтгэл зовоосон нэг асуудал нь эдгээрт ажиллахаар Монгол Улсад орж ирж байгаа вьетнам иргэдийн бичиг баримтын зөрчил юм. Вьетнам засварчдын ихэнх нь Монгол Улсад анх орж ирэхдээ 30 хоногийн жуулчны визээр хил нэвтэрдэг ба манай орны гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу зохих ёсны татвар хураамжаа төлж хөдөлмөр эрхлэх эрхтэйгээр оршин суудаг ажилчдын эзлэх хувь тийм ч хангалттай байж чаддаггүй байна. Манай оронд ажиллаж амьдардаг вьетнам иргэд зөвхөн автомашин засварын газар ажиллуулдаггүй. Үүнээс гадна хүнсний болон өргөн хэрэглээний бараа, цахилгаан бараа, техникийн эд анги манай оронд оруулж ирж байна. Мөн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхэлж ажил төрөл нь амжилттай явж байгаа вьетнам иргэд өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Тухайлбал, үсчний газар, уран сайхны гэрэл зургийн газар, хувцас прокат, гахай, тахианы аж ахуй байна.

БНСВУ 2007 оны 1-р сард ДХБ-д гишүүнээр элссэн¹⁵ нь Монгол, Вьетнам хоёр улсын хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаанд чухал хувь нэмэр оруулах боломж нээгдэж байна гэж үзэх бүрэн боломжтой.

Худалдаа эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын Комисс 1979 онд байгуулагджээ. Хэсэг хугацаанд үйл ажиллагаа нь тасраад байсан ЗГХК 1996 оноос хэвийн болж, нийт 12 удаа хамтарсан хуралдаан¹⁶ хийжээ.

Засгийн газар хоорондын Комиссын 8-р хуралдаан: Эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын 8-р хуралдаан 1996 онд Улаанбаатар хотноо болов. Хуралдаанаар хоёр тал 1990-ээд оноос зогсонги байдалд орсон эдийн засгийн харилцааг сэргээх, төвлөрсөн төлөвлөгөөнөөс чөлөөт зах зээлд шилжих үеийн хамтын ажиллагааны зохистой хэлбэрийн талаар ярьж, санал солилцов.

Засгийн газар хоорондын Комиссын 9-р хуралдаан: ЗГХК-ын 9-р хуралдаан 1999 оны 12-р сарын 10-14-нд Ханой хотноо болов. Хуралдааны үеэр талууд шинэ зуунд хамтын ажиллагааг харилцан ашигтай хөгжүүлэх арга замыг эрэлхийлж санал бодлоо солилцов. Хуралдааны үеэр Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын Худалдааны Хэлэлцээр, Монголын Үндэсний Телевиз, Вьетнамын Төв Телевизтэй хамтран ажиллах Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Засгийн газар хоорондын Комиссын 10-р хуралдаан: ЗГХК-ын ээлжит 10-р хуралдаан 2001 оны 10-р сарын 23-27-нд Улаанбаатар хотноо хуралдав. Тус хуралдаанаар Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах хэлэлцээр, боловсрол, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр Боловсролын яамд хоорондын 2001-2005 онд хамтран ажиллах хэлэлцээр, Монгол банк, Вьетнамын Улсын банк хооронд хамтран ажиллах тохиролцоонд гарын үсэг зурсан байна.

Хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид улам өргөжүүлж, худалдааны эргэлтийн хэмжээг 2005 онд 10 сая ам.долларт хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд тээврийн асуудал чухал үүрэгтэйг онцлон тэмдэглээд олон улсын төмөр замын ачаа тээврийн асуудлыг зохицуулах үүднээс БНХАУ-ыг оролцуулсан гурван талын уулзалтыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэв. 2002 оны 2-р сард болсон Монгол, Вьетнам, БНХАУ-ын олон улсын төмөр замын асуудлаар болсон гурван талт уулзалтын үеэр Монгол, Вьетнамын Төмөр замын хоорондын шууд хамтын ажиллагааны Протоколд гарын үсэг зурав. Протоколд төмөр замаар дамжин өнгөрөх Вьетнамын ачаа, бараанд ногдох татварыг 50 хувь хөнгөлөхөөр тусгасан байна.

Мөн Засгийн газар хоорондын Комиссын үйл ажиллагааг идэвхжүүлж өргөжүүлэх үүднээс Шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны дэд Комиссыг сэргээн байгуулах боломжийг судлаж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Вьетнам талын дэд комиссоо 2005 оны 2-р сард байгуулсан байна.

Засгийн газар хоорондын Комиссын 11-р хуралдаан: ЗГХК-ын ээлжит 11-р хуралдаан 2004 оны 12-р сарын 8-12-нд Ханой хотноо болов. Хуралдаанаар хоёр орны төр, засгийн тэргүүн нарын харилцан айлчлал, ЗГХК-ын өмнөх хуралдааны үеэр худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд харилцан тохирсон олон асуудал амжилттай хэрэгжиж байгаа боловч хоёр талын мөнгө, санхүүгийн боломж, зам тээврийн бэрхшээл, зарим тохиолдолд талуудын ажлын уялдаа, зохион байгуулалт, идэвх санаачлагаас шалтгаалан тасарч буй арга хэмжээнүүд байгааг талууд тэмдэглээд хоёр орны нөөц бололцоонд тулгуурласан, бодитойгоор хэрэгжих төсөл, хамтын ажиллагааны хэлбэрүүдийг сонгох, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг нь тогтоох чиглэлд түлхүү анхаарах нь зүйтэй гэдэгтэй санал нэг байв.

Засгийн газар хоорондын Комиссын 12-р хуралдаан: ЗГХК-ын 12-р хуралдаан 2006 оны 12-р сарын 18-21-нд Улаанбаатар хотноо болсон.

Хуралдаанаар Комиссын 11-р хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг 60%-тай байна гэж дүгнээд цаашид хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээ

хязгаарлагдмал, байгуулсан хэлэлцээ, тохиролцоог ажил хэрэг болгох асуудал хүсэн хүлээсэн хэмжээнд хүрээгүй байна гэж дүгнэв.

Боловсрол, соёлын харилцаа: БНСВУ-ын Ерөнхий сайдын 2004 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хооронд шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулан ажиллаж байна.¹⁷ Үүний дагуу хоёр улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамдуудын харилцаа улам эрчимжиж байгаагийн зэрэгцээ их, дээд сургуулиуд, судалгаа шинжилгээний болон соёл урлагийн байгууллагуудын харилцаа идэвхжиж байна. Тухайлбал, манай хоёр орны ШУА-уудын идэвхтэй харилцааг дурьдаж болох юм.

Монгол, Вьетнамын харилцааны 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Вьетнамын хөнгөн хөгжмийн театрын жүжигчид 2004 оны 4-р сард Монголд, харин 2006 оны 1-р сард Монголын дуу бүжгийн “Сарны чулуу” хамтлаг Вьетнамд айлчлан тоглов. ЭСЯ санаачлан Ханойд анх удаа 2004 онд Монголын ноолууран бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан байна.

Монгол, Вьетнам хоёр улсын Засгийн газар хооронд хийгдсэн боловсролын гэрээний дагуу 1996 оноос эхлэн жилд Монгол Улсаас 3 оюутан БНСВУ-д, харин БНСВУ-аас 2 оюутан Монгол Улсад тус тус Засгийн газрын тэтгэлгээр их, дээд сургуулиудад суралцаж эхэлсэн. Гэхдээ зөвхөн 1996 оноос эхлэн оюутан харилцан солилцож дээд боловсрол олгож байгаа биш юм. Манай хоёр орон 1950-аад оноос боловсролын салбарт хамтран ажиллаж эхэлсэн арвин туршлагатай билээ. 2004 онд Монгол Улсад хийсэн БНСВУ-ын Ерөнхий сайдын айлчлалын хүрээнд яригдсан нэг ач холбогдолтой зүйл нь хоёр орны Засгийн газар хоорондын боловсролын гэрээг шинэчлэн батлах асуудал юм. Үүний дагуу 2006-2010 онд боловсролын салбарт хамтран ажиллах гэрээг баталсан бөгөөд 2004-2005 оны хичээлийн жилээс эхлэн БНСВУ-д тус улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцдаг монгол оюутны тоог 5 болгосон ба энэ тоог 2007 оноос эхлэн жил бүр 5-аар нэмэгдүүлж, улмаар жилд 20 оюутан сургах, харин тус улсаас манай улсад суралцах оюутны тоог 3 болгож нэмэгдүүлсэн бөгөөд энэ ажил хэрэгжиж эхлээд байна. Зөвхөн Засгийн газрын тэтгэлгээр ч биш, хувийн зардлаар БНСВУ-д суралцахыг хүсэгчдийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа ба одоогоор нийт 50 орчим монгол оюутан Вьетнам улсад, 20 орчим вьетнам оюутан Монголд суралцаж байна.

1955 оноос хойш Вьетнамын 8 аспирант, 110 оюутан Монголд, мөн хугацаанд манай 20 гаруй оюутан Вьетнамд их, дээд сургууль төгссөн.

Хүмүүнлэгийн харилцаа: Манай улсын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд зориулж Вьетнам Улс 1993 онд 200 мянган ам.доллар,

ой хээрийн түймрийн хор хохирлыг арилгахад зориулж 15 мянган ам.долларын 2001 оны 5 сард, манай оронд нүүрлэсэн зудын гамшгийг гэтлэн давахад зориулж 2000 тн цагаан будаа, 2004 онд манай залуу үеийнхний оюуны санд хөрөнгө оруулалт хийж 300 ширхэг сүүлийн үеийн компьютерийн тусламжийг тус тус үзүүлсэн.

Өнгөрсөн хугацааны худалдааны тэнцлийн зөрүүгээс үүссэн Вьетнамд төлөх 400 орчим мянган шилжих рублийн өрийг Вьетнамын тал манай хүсэлтээр хүчингүй болгосноо 1995 онд нотолсон бөгөөд хэвлэлд албан ёсоор зарлахаас Вьетнамын тал татгалзсан байна. 1999 оны сүүлээр Вьетнамд болсон их үерт хүний амь нас хохирч, эд материалын ихээхэн хохирол учирсанд Монгол Улсын Засгийн газар эмгэнэл илэрхийлжээ. 2000 оны Монголд болсон их зуданд мал олноор хорогдож хохирол амсч байгаад эмгэнэл илэрхийлж Вьетнамын Ерөнхий сайдаас Монгол Улсын Ерөнхий сайдад эмгэнэл илэрхийлж цахилгаан утас ирүүлсэн байна. 2008 онд Монгол Улсад айлчлахдаа Ерөнхийлөгч Нгуен Минь Чиег Вьетнамын Засгийн газар Монгол Улсад нэг мянган тонн цагаан будаа, хэд хэдэн түргэн тусламжийн автомашин бэлэг болгон өгч, мөн ашгийн бус худалдааны нөхцлөөр 20 мянган тонн цагаан будаа нийлүүлэхээр шийдвэрлэснийг мэдэгджээ.

Дүгнэлт

Монгол, Вьетнам хоёр улс маш эртний түүхэн уламжлалт, найрсаг харилцаатай хэдий ч харилцаа, хамтын ажиллагаа нь улс төр, боловсрол, соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбарт түлхүү хөгжиж, худалдаа, эдийн засгийн харилцаа тааруу хөгжиж байна. Даяаршиж буй энэ үед гадаад бодлогын үзэл баримтлалын тэргүүлэх чиглэлүүдийн нэг болох уламжлалт харилцаатай орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, бүс нутгийн болон олон улсын тавцанд тэдний дэмжлэгийг авах шаардлага урган гарч ирж байгаа ба ийм ч учраас энэхүү түүхэн уламжлалт, найрсаг харилцаатай явж ирсэн Вьетнам улстай илүү ойртон түших зайлшгүй, нэн ялангуяа зөвхөн улс төрийн харилцааг голлох биш түүнээс гадна худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх боломж нөхцөл бий эсэх талаар судлахыг зорилоо.

Монгол, Вьетнам хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон тэр үеэс өнөөг хүртэл болосролын салбарт харилцаа, хамтын ажиллагаа бараг тасраагүй бөгөөд хамгийн сүүлд хийсэн хэлэлцээрийн дүнд одоо манай талаас суралцах оюутны тоог жилд 20 хүргэхээр болоод байгаа нь чамлахаар үзүүлэлт биш гэж үзэж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Дашцэвэл, С., “Монгол-Вьетнамын харилцаа 50 жилд”, *Монгол, Вьетнамын харилцаа-50 жил*, Улаанбаатар, 2005, 18-р тал.
2. Ишжамц, Н., Дашцэвэл, С., Хурметхан, М., *Монголын Эзэнт гүрний гадаад харилцаа*, Улаанбаатар, 1995, 99-р тал.
3. Мөн тэнд, 98-р тал.
4. Бор, Ж., “Монгол ба Зүүн Өмнөд Азийн улсуудын эртний харилцаа”, *Алтан аргамж*, Улаанбаатар, 1998, №2, 14-р тал.
5. Чулуун, Ц., *Бугд Найрамдах Ардчилсан Вьетнам Улс*, Улаанбаатар, 1970, 11-р тал.
6. МАХН-аас коммунист, ажилчны намуудтай тогтоосон харилцаанд холбогдох баримт бичиг, Улаанбаатар, 1981, 113-143-р тал.
7. <http://www.mongembhanoi.com>
8. Фам Хюй Чяу, “Вьетнамын хуа ястан Бээжингийн эрх баригчдын үндэсний харгис бодлогод өртөгдөж буй нь”, *Дорно дахин судлалын асуудал*, 1979, №2, 55-р тал.
9. Дашцэвэл, С., “Хятадын жанжлах үзэлтнүүдээс БНСВУ-ын эсрэг явуулж ирсэн эзлэн түрэмгийлэх бодлого”, *Дорно дахины судлалын асуудал*, 1979, №2, 60-р тал.
10. Мөн тэнд, 62-р тал.
11. Баасанхүү, Г., “БНСВУ бол Зүүн Өмнөд Ази дахь манай найдвартай түнш мөн”, *Монгол, Вьетнамын харилцаа-50 жил*, Улаанбаатар, 2005, 62-р тал.
12. Лхагвасүрэн, Д., “Монгол, Вьетнамын соёл, боловсролын салбар дахь харилцаа”, *Монгол, Вьетнамын харилцаа-50 жил*, Улаанбаатар, 2005, 82-р тал.
13. Гадаадын Иргэн, Харъяатын Асуудал Эрхэлсэн Газрын мэдээлэл.
14. <http://www.mofa.gov.vn>
15. Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын Комиссын хуралдаануудын тэмдэглэл.
16. Лхагвасүрэн, Д., “Монгол, Вьетнамын соёл, боловсролын салбар дахь хамтын ажиллагаа”, *Монгол, Вьетнамын харилцаа-50 жил*, Улаанбаатар, 2005, 85-р тал.